

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ
А.БЯМБАДОРЖИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилго 9. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааны стратегийг боловсруулах, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж чанар, аюулгүй байдлыг хангуулах							
Зорилт 1. Салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавих, үйл ажиллагаанаас учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах							
1.1. Хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, хяналт шалгалтын стратеги, эрх зүйн орчныг боловсронгуй болгох							
1	Арга хэмжээ 1.1.2 Газрын тос, хийн салбарын мөрдөх дүрэм, журам, ангилал, заавар, шаардлага, зөвлөмжийн төсөл, нэмэлт өөрчлөлт оруулахад санал өгөх.	Санал өгсөн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг саналыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас байгуулагдсан ажлын хэсэгт хэлэлцэв. - "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын нэмэлт, өөрчлөлтөд тусгах санал боловсруулан Хяналт, үнэлгээний үндэсний хороонд 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 11/744 тоот албан бичгээр хүргүүлэв. - Хууль, зүй дотоод хэргийн яамнаас ирүүлсэн "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам", "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт"	2025.01.01 2025.06.30	100

шинэчлэн батлах тухай тогтоолын төсөлд санал боловсруулж Хуулийн хэлтэст хүргүүлэв.

- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах байгууламжийн төлөвлөлт, ашиглалт болон түүнд тавих хяналт алдагдах нөхцөл бий болсон тул "Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах, галын аюулгүйн норм" БНД-ийг баталж мөрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02/102 дугаартай албан бичгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүүд хүргүүлэв.

- Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар байгуулагдсан Салбарын хяналт шалгалт давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн нэгжүүдэд учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, давхардлыг бууруулах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралд оролцож хяналт шалгалтын давхардал, шилэн хяналтын нэгдсэн удирдлагын цахим системийн үйл ажиллагаатай холбоотой зарим асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.

- Геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн болон цацрагийн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт гаргаж тамгын газарт хүргүүлэв.

- Барилгын хөгжлийн төвөөс 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 01/1230 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Том болон дунд оврын био хийн инженерийн

						байгууламжийн барилга байгууламжийн техникийн шаардлага" стандартын төсөлд санал боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/1230 дугаартай албан бичгээр хүргүүлэв.		
2	Арга хэмжээ 1.1.5 Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөх	Санал өгсөн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж хуулийн үзэл баримтлалын төслийг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцэж санал өгөв.	2025.01.01 2025.03.14	100	
3	Арга хэмжээ 1.1.7 Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулах.	Боловсруу лсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	- Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулж газрын тос, хийн хяналтын чиглэлээр 2 саналыг ТЗҮГ-т хүргүүлэв.	2025.01.01 2025.06.30	100	
4	Арга хэмжээ 1.1.13 Хяналт шалгалтын хяналтын хуудсыг шинээр болон шинэчлэн боловсруулах.	Шалгуур үзүүлэлтийн тоо	0	7	"Хий хадгалах дараалтат савны угсралт, ашиглалтын үйл ажиллагааг шалгах", "Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний хадгалаалтын үйл ажиллагааг шалгах", "Шингэрүүлсэн шатдаг хий цэнэглэх станцын үйл ажиллагааг шалгах", "Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах", "Автомашиныг хийгээр цэнэглэх станцын үйл ажиллагааг шалгах", "Шингэрүүлсэн шатдаг хийн тоног төхөөрөмжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагааг шалгах", "Шингэрүүлсэн шатдаг хий борлуулах цэгийг шалгах" хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/68 дугаар тушаалын 1, 8-14 дүгээр хавсралтаар тус тус батлуулан хяналт шалгалтад ашиглаж байна.	2025.01.01 2025.04.30	100	

1.2. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, тэлөвлөх, салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавих, тайлагнах.

5	Арга хэмжээ 1.2.1 Хяналт шалгалтын объектуудад 2026 оны эрсдэлийн үнэлгээ хийх	Хяналт шалгалтын нийт объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн хувь	0	0	Хугацаа болоогүй	2025.07.01 2025.11.30	-
6	Арга хэмжээ 1.2.3 Эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 273 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын төлөвлөгөө ний биелэлт, гүйцэтгэл /хувь/	0	70.3	- Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06-00/001 дугаартай удирдамжийн дагуу Газрын тос олборлох, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй аж 90 ахуйн нэгж, байгууллага, иргэний 192 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэлээ. Хяналт шалгалтаар нийт 1812 зөрчил дутагдал илрүүлж, 157 зөрчлийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай улсын байцаагчийн 1112 заалттай 147 албан шаардлага гаргаж хүргүүлэн, ноцтой зөрчил илэрсэн шатахуун түгээх 9 станцын үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл хугацаагаар түр зогсоож, зөрчил үйлдсэн 18 аж ахуйн нэгжид 18.000.000 төгрөгийн шийтгэл оногдуулж аж ахуйн нэгж байгууллагын 556 албан тушаалтанд газрын тос, хийн хяналтын чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгах арга, холбогдох хууль, дүрэм журам, стандартыг мөрдөх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хяналт шалгалтын дүнг нэгтгэн, танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг 2025.05.30-ны өдрийн 02/1701 дугаартай албан бичгээр Улсын онцгой комисст хүргүүлэв.	2025.01.01 2025.06.30	100

					Хяналт шалгалтад хамрагдах 273 объектаас 190 объект хамрагдаж, гүйцэтгэл 70.3%- тай ургэлжилж байна.		
7	Арга хэмжээ 1.2.5 Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх	Зөрчил гомдлын шийдвэрлэлт /хувь/	0	100	- "Петролеум продакшн" ХХК-аас 2025 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн №01/06 дугаартай албан тоотоор зөрчлийн талаар ирүүлсэн мэдээллийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж зөрчлийн АҮЭБЯ- 06/006/005 дугаартай хэрэг нээж Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэл оногдуулж шийдвэрлэв.	2025.01.01 2025.06.30	100
8	Арга хэмжээ 1.2.6 Газрын тос, хийн хяналтын чиглэлээр иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэх.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/	0	100	- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас газрын тос, хийн хяналтын чиглэлээр ирүүлсэн нийт 45 хүсэлтийг ирүүлсэнээс 10 хүсэлт хариугүй байлаа. Ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт 100 хувьтай байна. - Газрын тос, хий хадгалах даралтат сав, шугам хоолойд техникийн магадлал, баталгаажуулалт хийлгэх тухай 15 аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу ажиллаж хий хадгалах 73 даралтат савны техникийн магадлалын акт, баримтыг үндэслэн хянан баталгаажуулав - Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2025 оны 06/2624 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан 06-00/016 дугаартай удирдамжийн дагуу "Капитал авто сервис" ХХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт гүйцэтгэж танилцуулга боловсруулан 2025.02.17-ны өдрийн 11/522 дугаартай албан бичгээр АТГ-т хариу хүргүүлэв.	2025.01.01 2025.06.30	100

					<p>- Эм Кэй Эл ХХК, "Премиум иннова" ХХК-аас 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1/01 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ажлаж Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн 7.2.3 заалтын дагуу Даралтат савтай харьцаж ажиллах эрх олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хяnav.</p> <p>- Баялаг увс ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу ажилаж шатахуун түгээх станцын үйл ажиллагааны талаар зөвлөмж өгев.</p>	
--	--	--	--	--	--	--

1.3 Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх

9	Арга хэмжээ 1.3.1 Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй байгууллагын дотоод хэрэгцээний шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх.	Илэрсэн зэрчил арилгуулалт /хувь/	0	50	Улсын ерөнхий байцаагчийн баталсан "Байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглагдаж байгаа шатахуун түгээх станц үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай" 06-00/002 дугаартай удирдамжийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11/150 дугаартай албан бичгээр Нийслэлийн хяналт шалгалтын газарт хүргүүлсэн бөгөөд хяналт шалгалт үргэлжилж байна.	2025.01.01 2025.06.30	50
10	Арга хэмжээ 1.3.2 Олон нийтийн үйлчилгээний газар, худалдаа үйлчилгээний төвд ашиглагдаж буй шингэрүүлсэн шатдаг хийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт хийх /улсын хэмжээнд/	Илэрсэн зэрчил арилгуулалт /хувь/	0	50	Улсын ерөнхий байцаагчийн баталсан "Олон нийтийн үйлчилгээний газар, худалдааны төвд ашиглагдаж байгаа шингэрүүлсэн шатдаг хий, хийн тоног төхөөрөмж, хий борлуулах цэгийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай" 06-00/003 дугаартай удирдамжийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11/150, 11/151 дугаартай албан бичгээр Нийслэлийн хяналт шалгалтын газар болон 21 аймгийн Засаг даргын Тамгын	2025.01.01 2025.06.30	50

					газрын дарга нарт тус тус хүргүүлсэн бөгөөд хяналт шалгалт үргэлжилж байна.		
Баталгаажуулалтын хяналт							
11	Арга хэмжээ 1.3.11 Газрын тос, хий хадгалах даралтат сав, шугам хоолойд техникийн магадлал, баталгаажуулалт хийх	Техникийн магадлал, баталгаажуулалт хийсэн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Газрын тос, хий хадгалах даралтат сав, шугам хоолойд техникийн магадлал, баталгаажуулалт хийлгэх тухай 15 аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу ажиллаж хий хадгалах 73 даралтат савны техникийн магадлалын акт, баримтыг үндэслэн хянан баталгаажуулав	2025.01.01 2025.06.30	100

Зорилт 3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

3.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

12	Арга хэмжээ 3.1.1 TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Биелэлт гаргасан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	- Газар, хэлтсийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хуулийн хугацаанд гаргаж нэгжийн даргаар баталгаажуулж ажиллав. - Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх хяналт шалгалтын удирдамжуудыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 11/307 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	2025.01.01 2025.06.30	100
13	Арга хэмжээ 3.1.2 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	Хууль тогтоомжийг биелүүлж ажилласан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	- Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Аж үйлдвэр, эрдэс баялгийн зохион байгуулалтын нэгжүүд 2024 оны шийдвэрлэгдсэн баримтаа архивд шилжүүлэх хуваарь"-ийн дагуу 2024 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн албан бичгийг стандартын шаардлагын дагуу архивын хадгаламжын 1 нэгж нэгтгэн	2025.01.01 2025.06.30	100

	болов эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.					хадгаламжийн нэгж бүрдүүлж, архивт хүлээлгэн өгсөн. - Албан хаагчид 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд бөглөж, хянуулж баталгаажуулсан. - Байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор албан хаагчийн хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг цахимаар бөглөж, хянаж баталгаажуулсан.		
14	Арга хэмжээ 3.1.4 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2025 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөнд санал өгөх.	Санал өгсөн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	-Салбарын хяналтын газрын "Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний төслийг боловсруулав. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд санал өгөв. - Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болон аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулах хамтран ажиллах гэрээний төсөлд санал өгөв.	2025.01.01 2025.06.30	100	
3.2 Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх								
15	Арга хэмжээ 3.2.5 Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанд гишүүнээр оролцох	Хуралдаан д оролцсон эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанд гишүүнээр оролцож Очирт од прогресс ХХК-ийн Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх бага оврын үйлвэрийн ТЭЗҮ, Оюу толгой ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж байгаа Оюу толгой төслийн ТЭЗҮ-ийг хэлэлцэв.	2025.01.01 2025.06.30	100	

16	Арга хэмжээ 3.2.6 Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зөвлөлийн хуралдаанд оролцох	Хуралдаан д оролцсон эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зөвлөлийн хуралдаанд оролцох	2025.01.01 2025.06.30	100
17	Арга хэмжээ 3.2.8 Ашиглалтад бэлтгэсэн уурхай, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүд, газрын тос, хийн байгууламжийн шугам сүлжээ байнгын ашиглалтад хүлээн авах комисст ажиллах.	Ажлын хэсэгт тухай бүр томилогдон ажилласан эсэх: 1-тийм 0-үгүй	0	-	- Уурхай, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүд, газрын тос, хийн байгууламжийн шугам сүлжээ байнгын ашиглалтад хүлээн авах тухай хүсэлт, мэдэгдэл ирээгүй болно.	2025.01.01 2025.06.30	-
18	Арга хэмжээ 3.2.15 Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцох.	Тухай бүр төлөөлж ажилласан эсэх: 1-тийм 0-үгүй	0	-	- Засгийн газар болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцох тухай мэдэгдэл ирээгүй болно.	2025.01.01 2025.06.30	-
19	Арга хэмжээ 3.2.17 Салбарын улсын /ахлах/ байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	- “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний хяналтын чиглэлээр улсын хэмжээнд хийгдэж буй хяналт шалгалтад анхаарах асуудал” сэдвээр нийслэл, орон нутгийн газрын тос, хийн хяналт хариуцсан улсын байцаагч наарт онлайн сургалт хийж, зөвлөмж өгөв. Сургалтад Нийслэл, 20 аймгийн 21 улсын байцаагч хамрагдav.	2025.01.01 2025.06.30	100

20	Арга хэмжээ 3.2.19 Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд санал өгөх, гэрээний биелэлтийн явц, хэрэгжилтэд хяналт тавих.	Гэрээний хэрэгжилт /хувь/	0	1	- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд санал өгөв. - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтэст газрын тос, хийн хяналтын улсын байцаагчийн орон тоог бий болгох, салбарын хяналт шалгалтыг зохион байгуулж болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02/544 дугаартай албан бичгийг Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-алтай, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгийн засаг дарга нарт хүргүүлэв.	2025.01.01 2025.06.30	100
21	Арга хэмжээ 3.2.21 Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бүрдүүлбэрт хяналт тавих.	Хяналт тавьсан аж ахуйн нэгжийн тоо	0	103	- Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 103 аж ахуйн нэгж, байгууллагын баримт материалын бүрдүүлбэрийг хянаж мэргэжлийн инженер техникийн ажилтангүй, хяналт шалгалтаар өгсөн албан шаардлагын биелэлт хангагдаагүй зэрэг 17 аж ахуйн нэгжийн материалыг буцааж шаардлагын биелэлтийг ханггуулав. - Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн дагуу олгогдож буй тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын төсөл боловсруулж ГТБХЗГ-т хүргүүлэв. - Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй шатахуун хадгалах агуулах, савны түрээсийн гэрээний	2025.01.01 2025.06.30	100

					бүртгэлийн мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025.04.22-ны өдрийн 11/1186 дугаартай албан бичгээр авч тусгай зөвшөөрлийн бүрдүүлбэрт хяналт тавих ажилд хэрэглэж байна.	
--	--	--	--	--	---	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Салбарын аж, ахуйн нэгж байгууллага, инженер, техникийн ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах.	Сургалт зохион байгуулсан тоо	0	1	- ШУТИС-ын зөвлөх инженерийн зэрэг горилох сургалтад оролцогчдод “Шингэрүүлсэн шатдаг хийн хяналт шалгалтаар илэрч буй зөрчил дутагдал, анхаарах асуудал” сэдвээр сургалт хийв. - Газрын тосны салбарын 84, Геологи уул уурхайн сургуулийн 65 жилийн оид зориулсан “Газрын тос-2025” эрдэм шинжилгээ, онол, практикийн 31 дүгээр хуралд оролцов.	2025.01.01 2025.06.30	100
2	Цаг үеийн шинжтэй тусгамдсан асуудлыг хэлэлцэх хурал, зөвлөгөөнд оролцох	Тухай бүр гүйцэтгэсэн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Эрчим хүчний зохицуулах хорооноос зохион байгуулсан “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад шингэрүүлсэн шатдаг хийн технологийг нэвтрүүлэх боломж, шийдэл, анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож санал солилцов.	2025.01.01 2025.06.30	100
3	Эрсдэлээс урьчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тухай бүр гүйцэтгэсэн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	- “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ын хэрэгжилтийг хангуулах тухай саналыг 2025 оны 05 дугаар 12-ны өдрийн 11/1474 дугаартай албан бичгээр Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэв.	2025.01.01 2025.06.30	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
1	2	3	4	5	6	7	
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 1.1 Мэргэжлийн болон салбарын мэдлэгээ дээшлүүлэх хүрээнд холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдах.	Сургалт, семинар, хэлэлцүү лэгт хамрагдсан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	- Удирдлагын академийн Төрийн инновац, хөгжлийн албанаас зохион байгуулсан "Дизайн сэтгэлгээ" сургалтад хамрагдav. - Удирдлагын академийн Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад хамрагдav.	2025.01.01 2025.06.30	100
2	Арга хэмжээ 1.2 Салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор батлагдан гарсан баримт бичгийг хэрэгжүүлэх, программ төлөвлөлтөд анхаарч ажиллах	Батлагдан гарсан баримт бичгийг хэрэгжүүлэх, программ төлөвлөлт өдөр анхаарч ажилласан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор батлагдан гарсан баримт бичгийг өдөр тутмын албан ажилд хэрэгжүүлж, программ төлөвлөлтөд анхаарч ажиллаа.	2025.01.01 2025.06.30	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
АХЛАХ ШИНЖЭЭЧ

А.БЯМБАДОРЖ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭДЭВИЙН МӨНХЦЭЦЭГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

№	Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин						
				Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа		
1	2	3	4			5	6	7		
ЗОРИЛТ 1. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ХЯНАЛТ ТАВИХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ										
1.1 Хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, хяналт шалгалтын стратеги, эрх зүйн орчныг боловсронгуй болгох										
1	1.1.2	Геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн энергийн салбарын мөрдөх дүрэм, журам, ангилал, заавар, шаардлага, зөвлөмжийн төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	Санал өгсөн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	УУХҮСайдын 2021 оны 07 дугаар сарын 27 өдрийн А/195 дугаартай “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”-ийг өөрчлөх ажлын хэсэгт орж холбогдох саналыг тусгуулан ажиллаа.	I-IV улирал	100%		
2	1.1.3	Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөлд санал өгөх	Санал өгсөн байх 0-үгүй 1-тийм	0	1	Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлийн хэсэгт ажилласан.	I-IV улирал	100%		
3	1.1.4	Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх	Санал өгсөн байх 0-үгүй 1-тийм	0	1	Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх ажлын хэсгийн хуралд 2025 оны 02 дугаар сарын 04 өдөр оролцсон.	I-IV улирал	100%		

4	1.1.13	Хяналт шалгалтын хяналтын хуудсыг шинээр болон шинэчлэн боловсруулах	Хяналтын хуудасны тоо	23	24	Хяналт шалгалтанд ашиглах 6.6 кодтой "Геологи, хайгуулын ажлыг шалгах хяналтын хуудас"-ыг шинэчилэн боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/68 дугаар тушаалаар батлуулав.	I-II улирал	100%
1.2	Эрсдэлд сууринсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, төлөвлөх, салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавих, тайлагнах;							
5	1.2.1	Хяналт шалгалтын объектуудад 2026 оны эрсдэлийн үнэлгээг хийх	Хяналт шалгалтын нийт объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн хувь	100	100	Хяналт шалгалтын объектуудад 2026 оны эрсдэлийн үнэлгээг хийх ажил үргэлжилж байна.	I-IV улирал	100%
6	1.2.3	Эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 464 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын төлөвлөгөөн ийн биелэлт, гүйцэтгэл /хувь/	73.0	75.0	Тайлант хугацаанд төлөвлөсөн төлөвлөгөөт хяналт шалгалтууд төсөв байхгүй шалтгаанаар тодорхойгүй хугацаагаар хойшлуулав.	2025.01.02 2025.05.30	100%
7	1.2.5	Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх	Зөрчил гомдлын шийдвэрлэлт /хувь/	0.00	100.0	Тайлант хугацаанд газрын хэмжээнд зөрчлийн талаарх 1 гомдол мэдээлэл ирснийг Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 10.000 сая төгрөгийг торгуулийг барагдуулан ажилласан.		
8	1.2.6	Геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/	-	100.0	1. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын иргэн Д.Сүрэнжаваас 2025 оны 01 дүгээр сарын 27-ний өдөр ирүүлсэн гомдлын дагуу газар дээр нь комиссийн бүрэлдэхүүн ажиллаж орон нутагтай газрын маргаантай байгаа тул тухайн асуудлаа шийдвэрлэж байж комисс ажиллуулах шийдвэрийг гарган		

							ажиллаа. 2.Дорноговь аймгийн Айраг сумын иргэн Г.Батбаяраас ирүүлсэн гомдлын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 18 өдөр аймгийн СХГ-ын хүргүүлэн хяналт шалгалт хийлгэн хариуг хүргүүлж ажилласан.		
1.3 Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах.									
Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх									
9	1.3.3	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх /улсын хэмжээнд/	Хяналт шалгалтын гүйцэтгэл /хувь/	100	100	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 06-00/014 дугаартай удирдамжийг Салбарын улсын ерөнхий байцаагчаар батлуулан аймгийн Засаг даргын тамгын газруудад хүргүүлсэн. Хяналт шалгалт үргэлжилж байна.	2025.01.02 2025.05.30	100%	
ЗОРИЛТ 3. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ									
3.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.									
10	3.1.1	TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Биелэлт гаргасан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг хуулийн хугацаанд гаргаж нэгжийн даргаар баталгаажуулан ажиллав.	I-II улирал	100%	
11	3.1.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын	Хууль тогтоомжийг биелүүлж ажилласан эсэх: 1-тийм	0	1	1. Тайлант хугацаанд нийт 25 албан бичиг, хүсэлт ирсэнээс хариугүй 14, хариутай 10, хариутай албан бичгийн хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. 2. Авилгын эсрэг хууль, Нийтийн	I-II улирал		

		эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	0-үгүй			албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хугацаанд ХАСХОМ-ийг гаргаж, 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор баталгаажуулсан.		
12	3.1.4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2025 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөнд санал өгөх	Санал өгсөн эсэх: Тийм-1 Үгүй-0	0	1	1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025-2028 оны стратегийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан СХГ-аас хийх ажлыг төлөвлөгөөнд тусгуулах ажиллаа. 2. Салбарын хяналтын газрын “Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г боловсруулав. 3. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын 2024-2025 оны эмхэтгэлд Салбарын хяналтын газраас 2024 онд гүйцэтгэсэн онцлох ажлын мэдээллийг Аж үйлдвэрийн бодлогын газарт хүргүүлэв.	I-II улирал	
3.2	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх							
13	3.2.3	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн нөөцийн тооцоо хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанд оролцох	Хуралдаанд оролцсон эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн нөөцийн тооцоо хэлэлцэх салбар зөвлөлд нийт 61 тайлан ирсэн ба тайлант хугацаанд 10 удаа хуралдаж, 37 тайланг хүлээн авч 15 тайланг засвартайгаар, 5 нөөцийн тайланг буцаасан. 3 тайланг хурлаар хэлэлцүүлээгүй болно.	2025.01.02 2025.05.30	
14	3.2.8	Ашиглалтад бэлтгэсэн уурхай, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүд, газрын тос, хийн байгууламжийн шугам сүлжээ байнгын ашиглалтад оруулан, хүлээн авах комисст ажиллах.	Ажлын хэсэгт томилогдон ажилласан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/19 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах журмыг шинэчлэн	2025.01.02 2025.05.30	100%

						баталсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 5 уурхай, үйлдвэр хүлээн авах ажлын хэсэгт орж ажилласан.		
15	3.2.9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагаанд оролцох	Хуралдаанд оролцсон эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	<p>Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагаатай холбоотой дараах ажлын хэсгүүдэд орж ажилласан.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний III чуулган”-д оролцсон. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт оролцсон. 	2025.01.02 2025.05.30	100%
16	3.2.10	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах.	Хагас, бүтэн жилийн тойм мэдээ /тоо/	1	2	- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг шаардлагатай мэдээг гаргаж ОБЕГт хүргүүлэн ажиллаа.	2025.01.02 2025.05.30	
17	3.2.16	Геологи, уул уурхай, газрын тос, хий, цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн дотоод хяналтыг сайжруулах, аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж, чиглэл хүргүүлэх	Чиглэл хүргүүлсэн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа 4 аж ахуйн нэгжид дотоод хяналтыг сайжруулах, аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж хүргүүлэн ажилласан.	2025.01.02 2025.05.30	

18	3.2.17	Салбарын улсын /ахлах/ байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	Улсын Ерөнхий прокурорын газраас 2025 оны 06 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-ын хэрэглэгч наарт зориулсан сургалтад АҮЭБЯамны салбарын хяналтын газар, нийслэлийн салбарын хяналтын газар болон АМГТГ-ын улсын /ахлах/ байцаагчид хамрагдсан. Аймаг, нийслэл эрх олгогдсон байцаагчдад зориулсан цахим сургалтын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, 18 аймгийн нийт 45 улсын байцаагчид хамрагдсан.		
19	3.2.19	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд санал өгөх, гэрээний биелэлтийн явц, хэрэгжилтэд хяналт тавих.	Гэрээний хэрэгжилт, /хувь/	0.0	100.0	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Аймаг, нийслэлийн засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд оруулах саналыг боловсруулж 2025 оны 1-р сарын 10-ны өдөр дотоод албан бичгээр ТЗҮГ-т хүргүүлж улмаар гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			Эхэлсэн, дууссан хугацаа
1	2	3	4	5	6	7		
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1	Мэргэжлийн болон салбарын мэдлэгээ дээшлүүлэх хүрээнд холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдах	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан	0	1	1. Геологи, уул уурхайн салбарт үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журмууд болон шинээр батлагдсан хууль, тогтоомжуудын талаар мэдээлэлтэй	2025.01.02 2025.05.30	100%	

		ЭСЭХ: 1-тийм 0-үгүй			Болсон. 2. ОБЕГ-аас зохион байгуулсан “Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт”-д 2025.03.27-н ы өдөр, 3. Mining expo-2025 арга хэмжээнд 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр оролцсон.		
2	Салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор батлагдан гарсан баримт бичгийг хэрэгжүүлэх, программ төлөвлөлтөд анхаарч ажиллах	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан эсэх	0	1	1. Аймаг, нийслэл эрх олгогдсон байцаагчдад зориулсан цахим сургалтын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, 18 аймгийн нийт 45 улсын байцаагчид хамрагдсан. 2. Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, тогтоомжуудын дагуу Улсын Прокурорын байгууллагаас хийсэн сургалтад сууж мэдлэг, мэдээлэлтэй болсон.	2025.01.02 2025.05.30	100%

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Салбарын хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Даваадорж

.....

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах шинжээч

Ц.Мөнхцэцэг

2025.06.05

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
5 дугаар хавсралт

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	“Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт байрлах MV-004537 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “ЭБНЭ” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.	Салбарын хяналтын газрын дарга, салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 06-00/017 дугаартай удирдамж	Хяналт шалгалт хийсэн эсэх 0-үгүй 1-тийм	0	1	2025.04.01	2025.04.06

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Салбарын хяналтын газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Даваадорж

.....

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:

Ахлах шинжээч

Ц.Мөнхцэцэг

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ ЛОДОЙН ЦЭВЭЭНРАВДАНГИЙН 2025 ОНЫ
ЭХНИЙ 6 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		5		
1	2	3	4				6	7	
Зорилт 1. Салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавих, үйл ажиллагаанаас учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах									
1.1. Хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, хяналт шалгалтын стратеги, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;									
1	1.1.2 Геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн энергийн салбарын мөрдөх дүрэм, журам, ангилал, заавар, шаардлага, зөвлөмжийн төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	Санал өгсөн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	1. Аж Үйлдвэр, Эрдэс баялгийн Яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд санал өгсөн. 2. Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн төсөлд санал өгсөн.		2025.01.02 2025.06.10	100%	
2	1.1.3 Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөлд санал өгөх	Санал өгсөн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Газрын хэвлийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд экологийн цагдаагийн албан хаагч Зөрчлийн хэрэг үүсгэн шалгах хууль, эрх зүйн нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн өөрчлөлтийн 3 удаагийн хэлэлцүүлэгт оролцов.		2025.01.02 2025.12.31	100%	
3	1.1.4 Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл	Санал өгсөн эсэх:	0	1	Салбарын хяналтын газрын дарга Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн		2025.01.02 2025.12.31	100%	

	баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх	1-тийм 0-үгүй			найруулгыг хэлэлцэх ажлын хэсгийн хуралд оролцсон.		
4	1.1.6 Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөх	Санал өгсөн эсэх (Тийм:1, Үгүй:0)	0	1	Биелэлт тооцох хугацаа болоогүй байна.	2025.01.02 2025.12.31	100%
5	1.1.13 Хяналт шалгалтын хяналтын хуудсыг шинээр болон шинэчлэн боловсруулах	Боловс- руулсан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	Хяналт шалглатад ашиглах 6.6 кодтой “Геологи хайгуулын ажлыг шалгах хяналтын хуудас”, 6.7 кодтой “Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг шинэчлэн боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/68 дугаар тушаалаар батлуулав.	2025.01.02 2025.03.31	100%
1.2. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, төлөвлөх, салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавих, тайлгах							
6	1.2.1 Хяналт шалгалтын объектуудад 2026 оны эрсдэлийн үнэлгээг хийх	Үнэлгээ хийсэн объектын тоо			Биелэлт тооцох хугацаа болоогүй байна.	2025.01.02 2025.12.31	100%
7	1.2.3 Эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Өмнөговь, Дундговь, Дорнговь, Говьсүмбэр аймгуудын 61 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Гүйцэтгэл /хувь/	73%	2%	1.2025 онд Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн төсөл боловсруулахад оролцон батлуулсан. 2. Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооноос ирүүлсэн 2025 оны 16 дугаар хяналт шалгалт хийлгэх тухай хүсэлт, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 06-00/015 тоот төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байрлах Овоот толгойн нүүрсний уурхайн	2025.05.21 2025.06.10	100%

						ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Саусгоби сэндс” ХХК-ийн олборлолт, тээвэрлэлтийн ажилд гэрээгээр туслан гүйцэтгэгч “Синохайдро корпорейшн Монголия” ХХК үйл ажиллагаа эрхлэхдээ салбарын хууль тогтоомж зөрчсөн эсэхэд хяналт шалгалт хийх тухай чиглэлийг үндэслэн “Сино хайдро корпорейшн Монголия” ХХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн тухай танилцуулгыг удирдлагад танилцуулсан.		
8	1.2.5 Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх	Зөрчил гомдлын шийдвэрлэлт /хувь/	0.0	100.0	3. Тайлант хугацаанд төлөвлөсөн төлөвлөгөөт хяналт шалгалтуудыг тесвэв байхгүй шалгаанаар тодорхойгүй хугацаагаар хойшлуулав.	“Хорикаваметал” ХХК нь Увс аймгийн Хяргас сумын нутаг орших MV-010882, MV-015606 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд тус компани нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 48 дугаар зүйлийн 48.6 дахь хэсгийн 48.6.2 дахь заалтад зааснаар 2025 оны уулын ажлын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд төрийн захиргааны байгууллагад ирүүлээгүй тухай АҮЭБЯ - 06/004/012 бүртгэлийн дугаартай зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, Улсын төсвийн “100900000602-Хяналт шалгалтын орлого” дансанд 10 сая төгрөгийг төвлөрүүлэн Нийслэлийн Прокурорын газарт хянуулсан.	2025.01.02 2025.06.10	100%
9	1.2.6 Геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг	Шийд-вэрлэлт /хувь/	0.0	100.0	1. “Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2025 оны 06/2624 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан 06-00/016	2025.01.02 2025.06.10	100%	

	шийдвэрлэх.				дугаартай удирдамжийн дагуу "Капитал авто сервис" ХХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт гүйцэтгэж танилцуулга боловсруулан 2025.02.17-ны өдрийн 11/522 дугаартай албан бичгээр АТГ-т хариу хүргүүлэв. 2. Зөрчлийн талаарх 1 гомдол мэдээллийг шалган 1 аж ахуйн нэгжид нийт 10.0 сая төгрөгийн таргох шийтгэл оногдуулж, өргөдөл гомдол 1-г хүлээж авснаас 1-г хуульд заасан хугацаанд шийдвэрлэв		
--	-------------	--	--	--	---	--	--

1.3 Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах

10	1.3.13 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас олгох	Хяналтын хуудасны тоо		6	Аж ахуйн нэгжээс igov.mn цахим системээр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглах "Хяналтын хуудас"-ны 6 хүсэлт ирүүлснээс 6-г зөвшөөрч шийдвэрлэв.	2025.01.02 2025.12.31	100%
11	1.3.14 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх хуудас олгох	Тээвэрлэх хуудасны тоо		18	Аж ахуйн нэгжээс igov.mn цахим системээр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг "Тээвэрлэх хуудас" хүссэн 18 хүсэлтийг судалж, 18 хүсэлтийг зөвшөөрч шийдвэрлэв.	2025.01.02 2025.12.31	100%

Зорилт 3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

3.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна

